



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 09 өдөр

Дугаар 1/399

Чингис хот

Сургалт, зөвлөгөөн зохион байгуулахад
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.20 дахь заалтууд, Засгийн газрын 2017 оны “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам батлах тухай” 151 дүгээр тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны “Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, дэд хөтөлбөрийн жагсаалт батлах тухай” 02 дугаар, 2019 оны “Аймгийн 2020 оны төсөв батлах тухай” 08 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан хууль бус гар аргаар олборлогчдын үйл ажиллагааг нөхөрлөлийн хэлбэрт бүрэн оруулах, бичил уурхайн үйл ажиллагааг төлөвшүүлэх арга хэмжээний хүрээнд сургалт, зөвлөгөөн зохион байгуулахад 5000000 /таван сая/ төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс /С.Нямдаваа/-т, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар /Ж.Ганбаатар/-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231010468